

# МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 02 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

## Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын дүнг хэлэлцсэн тухай

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А-57 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори”-ийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан, дүгнэлтийг танилцуулав.

Тус байгууллагын санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийхэд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын холбогдох заалтуудыг зөрчсөн, санхүү төсвийн холбогдолтой гаргасан тушаал, дүрэм журмыг хэрэгжүүлээгүй, дагаж мөрдөөгүй дараах зөрчил дутагдал илэрсэн байна. Үүнд:

### **1. Төсвийн тухай хуулийн хүрээнд:**

**1.1** Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ тус хуулийн 16.5.2. “...төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 6.5.4. “Төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ...үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах”, 41.7.“Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, өөрийн орлого... гүйцэтгэлийн ил тод байдлыг хангах...” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, нэг ижил үйлчилгээнд өөр өөр тариф мөрдсөн зөрчил гаргасан.

Мөн Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн захирлын 2006 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 65 дугаар “Лабораторийн шинжилгээ, ажил, үйлчилгээний жагсаалт батлах тухай” тушаалын 01 дүгээр хавсралтаар батлагдсан лабораторийн шинжилгээ, мал эмнэлгийн ажил, үйлчилгээний хөлсний үнэлгээг мөрдөж ажиллаагүй зэрэг зөрчил дутагдал гаргасан байна. Тухайлбал, 2016 оны 07 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд тариф нэмэгдүүлсний улмаас 12,336,376.00 төгрөгийн орлого нэмж олсон, тариф бууруулсны улмаас 10,151,780.00 төгрөгийн орлого олох боломжийг алдсан, шинжилгээний нийт орлогыг 22,488,156.00 төгрөгийн зөрүүтэй тооцож төвлөрүүлсэн зөрчил гаргажээ.

**1.2** Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг зөрчиж, батлагдсан орон тоог 2015 онд 6 хүнээр хэтрүүлэн ажилласан, цалингийн зардалд 10.1 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 1.2 сая төгрөг, нийт 11.2 сая төгрөг хэмнэх боломжийг алдаж төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан байна.

**1.3** Тус хуулийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс 2014-2016 оны үндсэн үйл ажиллагааны

орлогыг нийт 38.6 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн, 2014 оны төсвийн зарлагыг 16.3 сая төгрөгөөр, 2015 онд 12.7 сая төгрөгөөр, 2016 онд 8.6 сая төгрөгөөр тус тус илүү төсөвлөсөн байна.

**1.4** Дээрх хуулийн 6.4.8. “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэсэн заалтыг зөрчиж 2015 онд 12,752.6 мянган төгрөгийн, 2016 онд 1,630.2 мянган төгрөгийн өр, авлагатай ажилласан байна.

**1.5** Их эмч А.Улаанхүүд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж 3,211,716 төгрөг олгосон боловч одоог хүртэл ажиллуулан цалин олгож байна. Үүнтэй холбоотойгоор цалинтай давхардуулан олгосон тэтгэмжийг суутган төсөвт буцаан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна.

## **2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд:**

**2.1** Тус хуулийн 67 дугаар зүйлийн 1. “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 2014 онд тендерээр нийлүүлэгдсэн 598.5 сая төгрөгийн шатаах зуух, 2012 онд нийлүүлэгдсэн 199.6 сая төгрөгийн үнэ бүхий явуулын лаборатори буюу нийт 798.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж ашиглалтгүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил гаргасан байна.

**2.2** Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс 2016 онд 5 нэр төрлийн 6.2 сая төгрөгийн эм урвалжийн материалыг хугацаанд нь ашиглаагүйгээс ашиглалтын хугацаа нь дуусаж ашиглах боломжгүй болсон тул төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил гаргасан байна.

## **3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд:**

**3.1** Тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн”; 5.1.4.”үнэн зөв байх;” гэсэн зарчмуудыг зөрчиж 2014 онд нийлүүлэгдээгүй нүүдлийн лабораторид автомашин болон холбогдох хэрэглэлийн хамт иж бүрнээр нь 112.4 сая төгрөгөөр бүртгэж авсан байна.

**3.2** Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу бүрэн хөтөлж тооллого тооцоог тогтсон хугацаанд бүрэн хийж, үр дүнг тооцох, төсвийн болон төсөл хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих дотоод хяналт хангалттай хэрэгжээгүй байна. Тухайлбал: Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын журмыг мөрдөж ажиллах, туслах үйл ажиллагааны орлогоос олсон мөнгөн хөрөнгийг хүлээн авснаас хойш Төсвийн харилцах дансанд ажлын дараагийн өдөрт шууд тушаах, гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**4.** Байгууллагын удирдлагын зүгээс өөрийн эрх мэдлийн хүрээнд тушаал, шийдвэр гаргах, байгууллагын дотоодод тавих хяналтыг сайжруулах, батлагдсан үнэ тарифыг мөрдөх ажил хангалтгүй хэрэгжсэн байна.

**5.** Баримт бичгийн хөтлөлт, боловсруулалтад Монгол Улсын стандарт MNS 51-2:2011, Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлагын 6.8. дахь хэсэг, 6.24. дэх хэсэг, Монгол Улсын стандарт MNS 51-3:2011, Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт тавих шаардлагыг мөрдөлт хангалтгүй байна.

Дотоод аудитын дүгнэлт, дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлын талаар хэлэлцээд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн

### **ТОГТООХ НЬ:**

1. Төрийн өмчийн хорооны 2009 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 315 дугаар тогтоолоор батлагдсан УТҮГ-ын дүрмийн 6.4.3-д тусгагдсаны дагуу шинжилгээний үнэ тарифыг Малын эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах гэсэн заалтын дагуу “Лабораторийн шинжилгээ, мал эмнэлгийн ажил, үйлчилгээний хөлсний үнэлгээг” шинэчлэн боловсруулж батлуулахаар сайдын тушаалын төсөл боловсруулж танилцуулахыг Бодлого төлөвлөлтийн газар /М.Энх-Амар/, Хуулийн хэлтэс /Б.Батцэцэг/ нарт, энэ хүрээнд Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн захирлын 2006 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 65 дугаар “Лабораторийн шинжилгээ, ажил, үйлчилгээний жагсаалт батлах тухай” тушаалыг хүчингүй болгохыг Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн захирал /Д.Батчулуун/-д даалгасугай.

2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 6.5.4 дэхь заалтууд, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.3 дахь заалтууд, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэхь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4 дэхь заалтуудыг зөрчсөн, Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын журмыг хэрэгжүүлээгүй зөрчил гаргасан. Мөн Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн захирлын 2006 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 65 дугаар тушаалаар батлагдсан лабораторийн шинжилгээ, мал эмнэлгийн ажил, үйлчилгээний хөлсний үнэлгээг мөрдөж ажиллаагүй зэрэг зөрчил дутагдлуудад дотоод хяналт тавьж ажиллаагүй байгууллагын удирдлагад хариуцлага тооцох асуудлыг судалж шийдвэрлэхийг Төрийн захиргаа удирдлагын газрын дарга /М.Мөнхбаясгалан/-д үүрэг болгосугай.

3. Хавсралтад дурдсан “Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори”-ийн дүрмийг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори /Д.Батчулуун/-д даалгасугай.

4. Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хяналтад авч, биелэлтийг дотоод аудитын хороонд тайлагнахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Совд/-д үүрэг болгосугай.

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ,  
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА**

**П.СЭРГЭЛЭН**

**УЛСЫН МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ  
ТАЛААР ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ**

1. Шинжилгээний бодит зардлыг тогтоох тооцоог нарийвчлан хийж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулж, шинэчлэн мөрдөх;
2. Оношилгоо, шинжилгээний үнэ тарифыг бүртгэлийн программ оруулах замаар санхүүгийн анхан шатны бүртгэлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
3. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөн холбогдох бичилтийг хийж тайлагнах;
4. Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын журмыг мөрдөж ажиллах, туслах үйл ажиллагааны орлогоос олсон мөнгө хөрөнгийг хүлээн авснаас хойш Төсвийн харилцах дансанд ажлын дараагийн өдөрт шууд тушаах, мөнгөн хөрөнгийн үйл ажиллагаанд өдөр тутмын дотоод хяналтыг хэрэгжүүлэх;
5. Санхүү эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;
6. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор төсвийн төлөвлөгөөг үндэслэлтэй, бодитой үр ашигтай, хэмнэлттэй байхаар боловсруулан батлуулж, зарцуулах;
7. Төсвийн тухай хуулийн 6.4.1.”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс 2014-2016 оны үндсэн үйл ажиллагааны орлогыг нийт 38.6 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн, 2014 оны төсвийн зарлагыг 16.3 сая төгрөгөөр, 2015 онд 12.7 сая төгрөгөөр, 2016 онд 8.6 сая төгрөгөөр тус тус илүү төсөвлөсөн зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллан, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;
8. Төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны урсгал зардлыг гэрээнд тодорхой тусган, батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаад хяналт тавьж ажиллах;
9. Батлагдсан орон тоог 2015 онд 6 хүнээр хэтрүүлэн ажилласны улмаас 10,1 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,2 сая төгрөгөөр нийт 11,2 сая төгрөгийн цалин хөлс НДШ-ийн зардлыг хэмнэх боломжийг алдсан зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, эрх бүхий Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан орон тооны хязгаарыг хатуу мөрдөж ажиллах;
10. Цалин, тэтгэмж давхардуулан олгосон зөрчлийг арилгаж, их эмч А.Улаанхүүд олгосон 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж 3,211,716 төгрөгийг суутган тооцож төсөвт буцаан төлүүлэх;
11. Гендерээр нийлүүлэгдсэн 598.5 сая төгрөгийн шатаах зуух, 199,6 сая төгрөгийн явуулын лаборатори нийт 798,1 сая төгрөгийн тоног төхөөрөмж ашиглалтгүй байгаа зөрчлийг арилгах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай;
12. Хөдөлмөрийн тухай” хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх заалт (25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна)-ын дагуу хөгжлийн бэрхшээлтэй 2-оос доошгүй иргэнийг авч ажиллуулах шаардлагатай;
13. Удирдлагын үйл ажиллагааг Монгол Улсын стандартын дагуу зөв баримтжуулах;

14. Захирамжлалын баримт бичиг /тушаал/-ийн хууль, эрх зүйн үндэслэл, хэрэгжилтэд хяналт тавих;

15. Архивын тухай хууль болон Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар баталсан Байгууллагын архивын үндсэн зааврын дагуу нөхөн бүрдүүлэлт хийх;

16. Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс 2016 онд 5 нэр төрлийн 6.180,916,25 төгрөгийн эм урвалж, материалын ашиглалтын хугацаа дуусан төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдсан байна. Иймд дээрх зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллан Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах,

17. Тайлант оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүссэн нөхцөл шалтгааныг санхүүгийн тодруулгад толилуулж байх, хөрөнгө худалдан авахтай холбоотой өр, авлага үүсгэхгүй байх;

18. Өмнөх онтой холбоотой өр, авлагыг тооцоо нийлж барагдуулах, харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тооцоо нийлсэн актаар баталгаажуулах хэвших.